



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

Улаанбаатар хот

2009 оны гуравдугаар сарын 19

№11 (584)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

181. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай Дугаар 22 157

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

182. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 53 163
183. Элчин сайдыг томилох, чөлөөлөх тухай Дугаар 54 163
184. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 55 163

Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

85. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 02 163

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

09 оны 03 дугаар
рын 03-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай

Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай улийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг дэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний төлөвлөгөө"-г 1 дүгээр всралтаар, "Нэн тэргүүнд боловсруулж, тлуулах шаардлагатай хууль, Улсын Их Хурлын сад шийдвэрийн төслийн жэгсаалт"-ыг 2 дугаар эсралтаар тус тус баталсугай.

2. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах чиглэлээр дараахь арга хэмжээ авч

ажиллахыг Засгийн газар /С.Баяр/, Монголбанк /Л.Пүрэвдорж/-нд үүрэг болгосугай:

1/Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулах;

2/энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад тусгагдсан банк, санхүү, төсөв, бодит салбарын үйл ажиллагааг дэмжих, тогтворжуулахад шаардагдах 1.5 их наядаас доошгүй төгрөгтэй тэнцэхүйц хөрөнгийг гадаад, дотоод эх үүсвэрээс нэн даруй олох арга хэмжээг авч ажиллах;

3/санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулахтай холбогдуулж нэн тэргүүнд боловсруулж батлуулах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх;

4/санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний явц, үр дүнгийн талаар Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулганд танилцуулах;

5/зээлийн хөрөнгөөр зөвхөн эргэн төлөгдөх нөхцөлтэй, экспортыг урамшуулсан, импортыг орлосон төслүүдийг санхүүжүүлэх.

3.Эдийн засгийн өсөлтийг хангах, бодит салбарын хөгжлийг дэмжих зорилгоор 2009 онд олон улсын бондын зах зээлд 1.2 тэрбум хүртэл ам.

доллартай тэнцэхүйц үнийн дүн бүхий Засгийн газрын бонд гаргах эрхийг Засгийн газар /С.Баяр/ олгосугай.

4.Энэ тогтоолыг Улсын Их Хурлаас хэлэлцэх явцад Монгол Улсын Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналуудыг уг тогтоолыг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг Засгийн газар /С.Баяр/, Монголбанк /Л.Пүрэвдорж/-нд тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь бүх 2009 оны 3 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагс мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭ

Монгол Улсын Их Хурлын 2009 оны
22 дугаар тогтоолын 1 дүгээр
хавсралт

**САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ
ДАВАН ТУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга зам	Хурал үр дүн	Шааргдах хөрөнгийн эх үүсвэр гэрбум төгрөг
1	Атрын 3 дахь явцын хүрээнд хаврын тариалалтыг сууцлук, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах. <ul style="list-style-type: none"> • малчид, хөдөөгийн иргэдийг дэмжих бодолын хүрээнд мал болон мал аж ахуйн гэрэлтэй түүхийг эд, болон ноос, ноолуур, явс шир, малын экспортыг хөгжүүлэх зорь туйл болон татварын талтай орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах. • мал аж ахуйн гэрэлтэй түүхийг эд болон малын үнийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах. Үг арга хэмжээг хэрэгжүүлэх чадваргүй тохиолдолд мал аж ахуй эрсэлцээд төрөөс татаас олгох зорь туйл орчныг бий болгож хэрэгжүүлэх. 	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайрын тушаал	Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хангамжийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг сөрөгөлгөө, импортын хүнсний хэрэгцээг бууруулах.	50.0
2	Үйлдвэрлэлийг дэмжих, мэдэлмэр эрэлтийг нэмэгдүүлэх. <ul style="list-style-type: none"> • жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх; • акцын байрыг дэдгэлэх; • акцын байр шинээр бий болгох; • олон нийтийн хамарсан хэвдэмжэр эрэлтийн хөтөлбөр хэрэгжүүлэх. 	Хөтөлбөр боловсруулж Засгийн газрын тогтоолоор батлах	Тодорхой шалтгаангүйгээр ажилгүй байгаа нийт иргэдийн 20 хургал хувийг ажил эрхэлтээд хамруулах, орлоготой болгох.	200.0
3	100 мянган айлын орон сууцны хөтөлбөрийг эрчимжүүлж, барилгын салбар дахь санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.	Засгийн газрын тусгаар	Акцын байрыг нэмэгдүүлж бизнесийн идэвхлэлийг сайжруулах, иргэдийн орон сууцны хангамж, амьдрал орчин мөхөөллийг сайжруулах.	80.0
4	Нийслэлийн авто замын завар, ар-салат болон шинээр авто зам барих ахуйг гүйцэтгэх.	Нийслэлийн Засаг дарга	Акцын байрыг нэмэгдүүлж бизнесийн идэвхлэлийг сайжруулах, нийслэлийн авто замын нөхцөлийг сайжруулах.	100.0

5	Эрчим хүчний сүлжээний аюулгүй байдлыг хангах, найдвартай байдлыг дээшлүүлэх.	Засгийн газрын тогтоол, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын тушаал	Төвийн эрчим хүчний дэд станцууд, дулааны цахилгаан станцуудын үндсэн тоноглогын зэвсгэр, үйлчилгээг дулааны улиралд гүйцэтгэх, халаалтын улирлын бэлтгэлийг бүрэн хангах замаар эрчим хүчний болзошгүй доголдол, дутагдлаас сэргийлэх.	60.0
6	Уул, уурхайн салбарыг дэмжиж экспортын орлогыг нэмэгдүүлэх: <ul style="list-style-type: none"> • нүүрс, төмрийн хүдрийн олборлолтыг нэмэгдүүлэх; • Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн дулааны цахилгаан станц барьж эрчим хүч экспортолж; • Монголбанкны алт худалдан авах механизмыг боловсронгуй болгох, 40.0 тонн алт олборлох зорилт тавих. 	Холбогдох хуульд өөрчлөлт оруулах, сайдын тушаал	Ажлын байрыг нэмэгдүүлж бизнесийн идэвхжилгийг сайжруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх.	300.0
7	Арилжааны банкуудаар дамжуулан бодит эрдийн засгийн салбаруудыг дэмжих.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	Банкны салбарыг дахин хөрөнгөжүүлэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор барилгын салбар, малчдад олгосон зээлийн асуудлыг шийдвэрлэх, хяналт шалгалтыг сайжруулах, төгрөгийн ханшигт тогтвортой байлгах.	400.0
8	Говийн бүсийн дэд бүтцийг байгуулах, хөгжүүлэх.	Засгийн газрын тогтоол	Ажлын байрыг нэмэгдүүлж, бизнесийн идэвхжилгийг сайжруулах.	290.0
9	Бага орлоготой өрхийг хямралын сөрөг үр дагавраас хамгаалах.	Сайдын тушаал, тендер зарлаж хэрэгжүүлэх	Хямралд хамгийн эхэнд өртөж, хүндээр хохирч болох ажилгүй, орлогогүй иргэд, өрх гэр бүлд чиглэсэн оногчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	50.0
	Шаардагдах нийт хөрөнгийн дүн			1,530.0

НЭН ТЭРГҮҮНД БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛАХ
ШААРДАГАТАЙ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН
БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн нэр	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн үзэл баримтлал	Хариуцах байгууллага	Хугацаа
1	Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	"Говь-Алтай, Завхан аймгийг эрчим хүчний төвлөрсөн сүлжээнд холбох хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх, улсын төсвийн орлого, зарлага, татаасын асуудал.	Сангийн яам	Улсын Их Хурлын 2009 оны ээлжит бус чуулган
2	Төв банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн эрх зүйн үндсийг бий болгох, хяналт шалгалтын эрх, үүргийг өргөжүүлэх.	Монголбанк	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
3	Хоронгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төсөл	Ипотечийн хоёрдогч зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлж, банкнаас олгосон орон сууцны урт хугацааны зээлийн хөрөнгийг эрсэлтэнд оруулж банкны мөнгөний урсгалыг сайжруулах.	Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
4	Үл хөдлөх эд хоронгөө барьцаалах тухай хуулийн төсөл	Үл хөдлөх эд хоронгөө, түүнтэй холбоотой эрх, үүргийн гүйцэтгэлийг хангаа баталгаа болгон барьцаалах, үл хөдлөх эд хоронгийн барьцааны гэрээ байгуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон хөрөнгийг зохицуулах.	Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
5	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төсөл	Хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний үйл ажиллагаатай холбогдсон хөрөнгийг зохицуулах.	Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
6	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, түүнээс санхүүгийн зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалт.	Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган

7	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөл	Улсын болон бус нутгийн ач холбогдолтой томсохон төслийг санхүүжүүлэх чадвар бүхий хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын үйл ажиллагааны асуудал.	Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
8	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны арга хэлбэр, зарчим, бизнес төрийн зүгээс учруулдаг дарамт шахалтыг багасгах, шаардлагагүй дүрэм, журмуудыг хүчингүй болгох, зөвшөөрлийн тогтолцооноос бүртгэлийн тогтолцоонд шилжих.	Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
9	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	7 хоногийн ажлын цаг, илүү цагийн хөлсийг боловсронгуй болгох асуудал.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
10	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Банкны байгууллагын санхүүгийн үйлчилгээний хүрээ өргөтгөн, хяналт шалгалтыг нэгдмэл цэгц байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх.	Монголбанк	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
11	Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөл	Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн банканд итгэх итгэлийг нэмэгдүүлж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг бэхжүүлэн, банкны байгууллагад тавигдах хяналтын тогтолцоог боловсронгуй болгох. Эдийн засгийн харьяат хоорондын болон харьяат бусгай хийх гадаад валютын аливаа гүйлгээ, гадаад валютын дотоодын захын зохицуулалт, валютын зохицуулалтын талаархи төрийн эрх бүхий байгууллагуудын эрх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан, мэдээлэл, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах. Гадаад валютын эрх зүйн орчныг өнөөгийн нөхцөлд нийцүүлж, валютын санхүүгийн шинэ хэрэгсэл хэрэглэх.	Монголбанк	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
12	Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн банканд итгэх итгэлийг нэмэгдүүлж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг бэхжүүлэн, банкны байгууллагад тавигдах хяналтын тогтолцоог боловсронгуй болгох. Эдийн засгийн харьяат хоорондын болон харьяат бусгай хийх гадаад валютын аливаа гүйлгээ, гадаад валютын дотоодын захын зохицуулалт, валютын зохицуулалтын талаархи төрийн эрх бүхий байгууллагуудын эрх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан, мэдээлэл, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах. Гадаад валютын эрх зүйн орчныг өнөөгийн нөхцөлд нийцүүлж, валютын санхүүгийн шинэ хэрэгсэл хэрэглэх.	Монголбанк	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
13	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Алтанд ногдуулах татварыг хүчингүй болгох.	Сангийн яам, Монголбанк	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган

14.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, иргэдээ эх орны хөрөнд тарьж ургуулсан, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, зөлийн балыг хямд үнээр худалдан борлуулах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.4 дэх заалтад "Монгол Улсын нутаг дэвсгэрт тарьж, үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, зөлийн бал" гэж нэмэх.	Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
15.	Төгрөгөөр төлбөр тооцоо гүйцэтгэх тухай хуулийн төсөл		Сангийн яам, Монголбанк	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
16.	Концессийн тухай хуулийн төсөл		Хууль зүй, дотоод хэргийн яам	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
17.	Итгэлцлийн тухай хуулийн төсөл		Монголбанк	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
18.	Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
19.	Боловсрол, эрүүл мэндийн салбарыг дэмжих санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах хөтөлбөрийн төсөл		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
20.	Хувийн хэвшилд баталгаа гаргах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Засгийн газар, Монголбанкнаас баталгаа гарган хөрөнгө босгоход дэмжлэг үзүүлж бодит эдийн засгийн салбарыг дэмжих.	Сангийн яам, Монголбанк	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган
21.	Төмөр замын тээврийг сэргээн сайжруулах хөтөлбөрийн төсөл		Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам	Улсын Их Хурлын 2009 оны хаврын ээлжит чуулган



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

009 оны 03 дугаар
арын 05-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах,
томилох тухай

Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16-гаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан АРЛИГ БОЛГОХ нь:

Элчин сайд Пэрэнлэйн Үржинлхүндэвийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Мексикийн Нэгдсэн Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Хасбазарын Бэхбатыг томилсугай.

1. Монгол Улсаас Мексикийн Нэгдсэн Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

009 оны 03 дугаар
арын 10-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар
хот

Элчин сайдыг томилох,
чөлөөлөх тухай

Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16-гаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан АРЛИГ БОЛГОХ нь:

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Жамбалдоржийг тохоон томилсугай.

2. Галсангийн Батсүхийг Монгол Улсаас Шинэ Зеланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

1. Монгол Улсаас Шинэ Зеланд Улсад суух

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

09 оны 03 дугаар
арын 10-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах,
томилох тухай

Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16-гаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан АРЛИГ БОЛГОХ нь:

Бүрэн эрхт Элчин сайд Яйчилын Батсуурийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсандоогийн Дашпүрэвийг томилсугай.

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суугаа Онц бөгөөд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

09 оны 03 дугаар
арын 11-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, "длын хуралдааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд П.Очирбат/илтгэгч/, Ж.Болдбаатар,



Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй нарийн бичгийн дарга Н.Болортунгалагийг оролцуулан Цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч Баянгол дүүрэг 13 дугаар хорооны оршин суугч, иргэн Р.Очирбал, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Су. Батболд нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Жардугаар зүйлийн 2, Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг: Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар хорооны оршин суугч, иргэн Р.Очирбал Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээлэлдээ:

"1. ... Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн "Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд тухайн Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр тараахыг хориглоно" заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэж байна.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д "Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсхүл дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно", мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" хэмээн заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн

хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуул оролцуулна" мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Нутги өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээн асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрл үл болно..." гэсэн Үндсэн хуулийн заалтыг шу зөрчсөн гэж үзэж байна.

3. Монгол Улсын засаг захиргаа, нут дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуули 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн "Энэ хуули 26.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.2 заасан эрх бүхий албан тушаалтан томилохо татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дот энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг дарг дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүх албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авсна хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гарг үүрэгтэй" гэж заасан нь Үндсэн хуулийн Жардуга зүйлийн 2 дахь хэсгийн "Засаг даргыг тухайн айм нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас н дэвшүүлж аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнх сайд; сум, дүүргийн Засаг даргыг харъяалах айм нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг дарг харъяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрө жилийн хугацаагаар томилно" гэсэн заалт агууллагаараа зөрчсөн гэж үзэж байна" гээд өөри шаардлагын үндэслэлийг доорхи байдла тайлбарласан байна. Үүнд:

"1. Хурал бүрэн эрхээ хэрэгжүүл боломжгүй гэж хуралдаанаараа үзсэн, цааш хурал үйл ажиллагаа явуулах бодит боломж болсон, хамтран ажиллах нөхцөлгүй хэмээн үзс тохиолдолд хурлын бүрэн эрхийн хугацаа 2 жил; дээш хугацаа өнгөрсөн л бол өөрсдөө хүссэн ч та чадахгүй байгаа нь иргэдийг төлөөлөх ардчилс ёсны зарчим болон ард түмний өмнө улс төрү хариуцлагаа хүлээн тарах талаархи шударга ёс зарчмыг зөрчсөн гэж үзэж байна.

Ерөөс аймаг, нийслэл, сум, дүүргийн Хур нь орон нутгийн түвшинд нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн асуудлыг бие да шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ тухв засаг захиргааны нэгжид байнга оршин сууж бай сонгуулийн насны иргэдээс бүх нийтийн, чөлөөт шууд саналаа өгөх эрхийн үндсэн дээр нууц сонгогддог. Төлөөллийн ардчиллын зарчим ёс Хурал бүрэн эрхийн хугацаандаа хуулиар олгогд чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаа, хууль!

ийл ажиллагаа явуулсан цаашид энэ байдлаараа гэмтран ажиллах боломжгүй хэмээн тухайн сонгогчдын дийлэнх олонхи үзэж Хурлын бүрэн ирхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох ирхтэй билээ.

Иргэдийн энэхүү эрхээ хэрэгжүүлэх бодит ололжийг ... 2 жилээс дээш хугацаа хэтэрсэн охиолдолд ... хугацаагаар хязгаарласан амгаалалтын систем амь бөхтэй байж, улмаар ууль бус үйл ажиллагаа, хариуцлагагүй байдал азар авсан ч иргэд өөрсдийн сонгосон Хурлыг араас эрхгүй болгосон нь Үндсэн хуульд заасан аргын эрх ард түмнээс үүдэлтэй байх ардчилсан сны зарчим, хариуцлагагүй, хууль бус үйл ажиллагааны төлөө улс төрийн хийгээд, хууль зүйн ариуцлага хүлээх шударга ёсны зарчмыг зөрчсөн айх үндэслэлтэй хэмээн үзэж байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зөрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, үүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний зүйн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие жаж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн зартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион зйгуулж оролцуулна" мөн зүйлийн 2 дахь хэсэгт "утгийн өөрөө удирдах байгууллагын эрх мжээний асуудлыг дээд шатны байгууллага нь ийдвэрлэж үл болно..." хэмээн тус тус заасан нь лгийн өөрөө удирдах байгууллага нь хуулиар тгосон тусгайлсан чиг үүрэг, эрх хэмжээтэй йгээд тухайн бүрэн эрхээ хэрэгжүүлэх бодит хийн чадамжийг хангахын тулд дээд шатны йгууллага тухайн нутгийн өөрөө удирдах йгууллагын эрх хэмжээний асуудлыг ийдвэрлэхгүй байх зарчмыг бэхжүүлсэн явдал и. Гэвч Монгол Улсын засаг захиргаа, нутаг өсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 1 дугаар зүйлийн 25.4-д "Хурлаас гаргасан тоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн зрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, хүл дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй лгоно", мөн зүйлийн 25.5-д "Аймаг, нийслэлийн рлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын йдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал рчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" хэмээн асан нь Үндсэн хуулийн дээрх заалтуудыг шууд рчсөн гэж үзэж байна. Учир нь нутгийн өөрөө ирдах ёсны байгууллага нь өөрийн нутаг

дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх хийгээд, энэхүү эрх нь тухайн байгууллагаас өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлыг шийдвэрлээд батлан гаргасан аливаа шийдвэр, тогтоолыг бусад байгууллага, албан тушаалтан шууд хүчингүй болгох боломжоос хамгаалагдсан байх ёстой.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран гуравдугаар зүйлд Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар харъяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байна хэмээн заасан боловч уг зүйлд орон нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг дээд шатны хурал эсхүл Улсын Их Хурал хүчингүй болгоно гэсэн агуулга байхгүй, байх ч боломжгүй. Хэрэв тухайн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй гэж үзвэл дээд шатны Хурал эсхүл хууль тогтоох байгууллагаас шийдвэрийг хүчингүй болгох бус зүүхийн байгууллагаас хүчингүй болгох нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь Хурал өөрийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлээд гаргасан шийдвэрийг дээд шатны Хурал, эсхүл Улсын Их Хурал хүчингүй болговол энэ нь өөрөө удирдах байгууллагын хэвтээ түвшний харилцааны зарчмыг зөрчин өөрөө удирдах ёсны тогтолцоонд харшилна гэж үзэж байна.

3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн "Энэ хуулийн 26.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.3-т заасан эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй" гэж заасан нь Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, сум дүүргийн Засаг даргыг харъяалах аймаг нийслэлийн Засаг дарга, баг, хорооны Засаг даргыг харъяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно" гэсэн заалтыг агууллагаараа зөрчсөн гэж үзэж байна.

Үндсэн хуульд зааснаар Засаг дарга нь тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгч болдог. Өөрөөр хэлбэл Засаг дарга нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтолцоонд хамаарах агууллагаараа заавал дээд шатны Засаг даргын шийдвэрээр томилогддог. Учир нь дээд шатны Засаг дарга, доод шатны Засаг даргатай харилцахдаа захирах, захирагдах ёсны зарчмаар ажилладаг бөгөөд хамтран ажиллах, харилцан итгэлцлийн улс төрийн зарчмыг авч үзэхгүйгээр өөр үнэлэмж, өөр бодлоготой албан тушаалтнууд төрийн үйл хэргийг захирах, захирагдах ёсонд нийцүүлэн хэрэгжүүлэх боломжгүй.

Иймээс л Үндсэн хуульд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг томилно хэмээн заасан. Гэтэл Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн агууллагаас харахад хэрэв Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг томилохоос татгалзсан тохиолдолд Хурал 15 хоногийн дотор Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга дараагийн нэр дэвшүүлсэн хүнийг шууд томилох үүрэгтэй байхаар тэр бүү хэл Хурал өмнө нь санал болгосон хүнээ дахин томилуулахаар санал гаргах эрхтэй бөгөөд тэрхүү санал болгосон Засаг даргыг Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга томилох үүрэгтэй байхаар заасан нь Үндсэн хуульд заагдсан Засаг даргыг томилох Ерөнхий сайд болон дээд шатны Засаг даргад Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг дордуулсан гэж үзэж байна” гэжээ.

Хоёр: Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн талбартаа:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгт “Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр тараахыг хориглоно” гэж заасан нь нэгэнт Хурал бүрэн эрхийнхээ хугацааны талаас илүү хувийг эдэлчихсэн тохиолдолд нутгийн өөрөө удирдах ёсны хэвийн үйл ажиллагааг хангах, өөрөөр хэлбэл удирдлагыг байнгын тасралтгүй явуулах үүднээс дараагийн Хурлын бүрэн эрх

эхлэх хүртэл Хурал өөрийн бүрэн эрхэ хэрэгжүүлэх баталгаа хийгээд үүргийг зохицуулс юм. Энэ нь ойр ойрхон сонгууль явуулсанаас гарч төсвийн мөнгийг хэмнэх, нөгөө талаас Хурль тэргүүлэгчид 4 жилийн хугацаанд хэвийн үй ажиллагаа явуулах үүргийг хүлээн зөвшөөрч ар түмнийг төлөөлөх болсон, харин ард түмэн хуулиг тогтоосон энэхүү 4 жилийн хугацаанд Хурль тэргүүлэгчдэд тодорхой үүргүүдий гүйцэтгүүлэхээр нэгэнт сонгосон учир Монг Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг түүний удирдлагын тухай хуулийн 15.1.1, 15.1.2 заасан үндэслэлээр Хурлыг тараахыг хориглс өгсөн юм.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Жарч хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөр удирдах байгууллагын эрх хэмжээний асуудли дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болн Хэрэв тухайн нутаг дэвсгэрийн амьдраль тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хуул төрийн зохих дээд байгууллагын шийдвэ тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирд байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие да шийдвэрлэж болно” хэмээн нутгийн өөрөө удирд байгууллагын хуулиар олгосон тусгайлсан чиг үү хийгээд эрх хэмжээг бэхжүүлж өгсөн.

Түүнчлэн Монгол Улсын засаг захиргаа, нут дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуули 3 дугаар бүлэгт нутгийн өөрөө удирдах байгуулла буюу Хурал, тэргүүлэгчид, Хурлын дарг тэдгэрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрл асуудлуудыг нарийвчлан зааж өгсөний зэрэгцээ э үүргээ хэрэгжүүлэхдээ гаргасан шийдвэр нь Монг Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргас Монгол Улсын Засгийн газрын шийдвэ харшлахгүй байх учиртайг мөн адил хуульчилс

Монгол Улсын засаг захиргаа, нут дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуули 25 дугаар зүйлийн 25.4, 25.5-д “Хурлаас гаргас тогтоол бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засг газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг туха эсхүл дээд шатны Хурал хүчингүй болгоно”, “Айм нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоо Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүн Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй бол эрхтэй” гэж заасан нь нутгийн өөрөө удирд байгууллагыг Монгол Улсын хууль тогтоомж



өөрчсөн шийдвэр гаргахаас хамгаалсан зохицуулалт болсон.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д заасан «... дээд шатны хурал хүчингүй болгоно» гэсэн нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, үүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар бүлэгт утгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээнд амаарах асуудлыг шийдвэрлэж буй хэрэг бус арин нэгэнт гаргасан шийдвэрийг Монгол Улсын ууль тогтоомжид нийцүүлэх хөшүүрэг юм.

3. Монгол Улсын Үндсэн хуулиар төрийн эрх эдлийг засгийн гурван салаанд хувиарлаж, удирдлагын босоо ба хөндлөн тогтолцоог хослуулах рактикт нэвтрүүлсэн юм.

Тухайлбал засаг дарга нь дээрээс эмилэгдэж тухайн нутаг дэвсгэрт хууль биелүүлэх ажлыг өөрөөр хэлбэл, гүйцэтгэх эрх мэдлийг засгийн газрын өмнөөс хэрэгжүүлдэг боловч ирлээс нэр дэвшигдэж, Хурлын шийдвэрийг эргэжүүлэх ажлыг нэгэн зэрэг эрхлэн гүйцэтгэх хувьд нутгийн өөрөө удирдах байгууллагын зарим шинжийг агуулсан байдаг.

Үүний илрэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт «Засаг иргэдийн тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, иргэдийн Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн засаг даргыг Ерөнхий сайд, сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга, иргэдийн Засаг даргыг харьяалах сум, дүүргийн засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар мило», мөн зүйлийн 3 дугаар хэсэгт Ерөнхий иргэдийн буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг милохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт асан журмаар дахин нэр дэвшүүлж томилогдох нөхцөл Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална» гэж тус тус зааснаар баталгааждаг.

...Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн «Энэ хуулийн 2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.3-т заасан эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий

албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй» гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчих бус харин Үндсэн хуулийн Жардугаар зүйлийг амьдралд хэрэгжүүлэх, түүнийг хугацаа зааж баталгаажуулсан зохицуулалт юм.

Түүнчлэн, орон нутагт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтныг томилохдоо ард түмний төлөөлөл болсон нутгийн өөрөө удирдах байгууллагын саналыг үндэслэж шийдвэрлэх нь төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны харилцан хяналт, хамарал бүхий тогтолцоог төлөвшүүлэхэд түлхэц болж байгаа билээ» гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгт «Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд тухайн Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-д заасан үндэслэлээр тараахыг хориглоно» гэсэн заалт нь иргэдээс төлөөллийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхээ хэрэгжүүлэх боломжийг хэт урт хугацаагаар хязгаарлаж, улмаар өөрөө удирдах ардчилсан ёсны зарчим, аливаа хууль бус үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээлгэх шударга ёсны зарчмыг алдагдуулж Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн «Ардчилсан ёс, шударга ёс... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн» гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн «Хурлаас гарсан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсвэл дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно»; мөн зүйлийн 25.5 дахь хэсэгт «Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй» гэсэн заалтууд холбогдох засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Хурал, Улсын Их Хурал нь өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд хөндлөнгөөс оролцох боломжийг бүрдүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэр хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харъяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн эсэх тухай асуудлаар гарсан маргаан нь шүүх харъяалан шийдвэрлэх асуудал байх тул Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэстэй байна.

3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг нь тухайн Хурал, Ерөнхий сайд, дээд шатны Засаг даргын шийдвэр гаргах хугацааг зохицуулсан байх бөгөөд Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдын холбогдох шатны Засаг даргад нэр дэвшигчийг томилох, томилохоос татгалзах бүрэн эрхийг дордуулсан гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн "Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд тухайн Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр тараахыг хориглоно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг; Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "... эсхүл дээд шатны..." гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн

"Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийг хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдрал асуудлыг бие дааж шийдвэрлэх...", мөн зүйлийн дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллага эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага шийдвэрлэж үл болно..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн "Энэ хуулийн 26.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.3 заасан эрх бүхий албан тушаалтан томилохос татгалзал зохих шатны Хурал 15 хоногийн дотс энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг дарга дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснай хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргч үүрэгтэй" гэсэн заалт нь Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг; мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "... эсхүл дээд..." гэсэн хэсэг; тус зүйлийн 25.5 дахь хэсгийг заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн үйлчлэлийг түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасна; Улсын Их Хурлын чуулганы хуралдаан эхэлснэ хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, харч ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Ж.БЯМБАДОРЬ
П.ОЧИРБА
Ж.БОЛДБААТА
Ж.АМАРСАНА
Ц.САРАНТУЯ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон-128 тоот

☎ 262420
Индекс 14003

☎ 329467
Хэвлэлийн хуудас 1.5